



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 09 өдөр

Дугаар A/511

Улаанбаатар хот

“Хот төлөвлөлт, судалгааны институт”
ОНӨААТҮГ-ын балансаас хөрөнгө
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,436,428 /есөн сая дөрвөн зуун гучин зургаан мянга дөрвөн зуун хорин найман/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ /Ч.Рэгзмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Г.Баттогтох/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ /Ч.Рэгзмаа/, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Г.Баттогтох/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА

115060001365

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 12 сарын 09 өдрийн А/ЭМ/... дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ

/төгрөгөөр/

№	Хөрөнгийн нэр	Марк, үзүүлэлт	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо шир-хэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Компьютер	i7, 12gbRAM, GeForceGT330VGA, 1Tb sata	2010-12-01	ш	1	2,079,000.0	2,079,000.0	2,079,000.0	-	Нийслэлийн Автозамын хөгжлийн газар
2	Компьютер	i7-940, 6gbRAM, AMD Radeon HD5700, VGA, 2Tb sata, dell s2340l	2011-11-01	ш	1	4,650,000.0	4,650,000.0	4,650,000.0	-	
3	Компьютер	i7-920, 16gbRAM, GeForceGTX750VGA, 1Tb sata	2009-12-01	ш	1	2,707,428.0	2,707,428.0	2,707,428.0	-	
Тонг төхөөрөмжийн дүн							9,436,428.0	9,436,428.0	-	